



ШВЕДИЙН ХААНТ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Захиргааны эрх зүйн маргаан)¹

СКҮҮТЕР ТҮРЭЭСЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМААРАХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 54-20, VOI Technology AB (нэхэмжлэгч) v. the Swedish Tax Agency (хариуцагч)

Шүүхийн шийдвэрийн огноо: 2020 оны 06 дугаар сарын 04-ны өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Швед улсад хуульд зааснаар нэмэгдсэн өртгийн албан татварыг 25 хувиар ногдуулдаг боловч зорчигч тээврийн үйлчилгээнд үүнээс 6 хувиар бага татвар ногдуулдаг. Нэхэмжлэгч болох VOI Technology AB компани нь тодорхой бүс нутагт тээврийн хэрэгслийн зориулалтаар ашиглах цахилгаан скүүтерийн үйлчилгээ үзүүлдэг байна. Хэрэглэгч нь гар утсаа ашиглан цахилгаан скүүтер дээрх QR кодыг уншуулснаар хэрэглэгчээс тодорхой мөнгөн дүнгээр тогтоосон төлбөр авах бөгөөд хэрэглэгч скүүтерийг ашиглаж дууссаны дараа скүүтер ашигласан хугацаанаас хамаарч нэмэлт төлбөр тооцогддог.

Тус компани өөрсдийн үзүүлж буй үйлчилгээг зорчигч тээврийн үйлчилгээний татварын хөнгөлөлтөд хамруулах эсэхийг тодорхойлуулахаар Швед улсын Татварын агентлагт хүсэлт гаргасан. Гэвч агентлагаас тус үйлчилгээг зорчигч тээврийн бус, харин тээврийн хэрэгсэл түрээслэх үйлчилгээ гэж үзэж, тухайн үйлчилгээнд 25 хувийн татвар ногдуулах шийдвэр гаргасан байна. Үүнтэй холбоотойгоор VOI Technology AB компани Швед улсын Захиргааны хэргийн дээд шүүхэд хандан, агентлагийн шийдвэрийг хүчингүй болгуулах, тус үйлчилгээг зорчигч тээврийн үйлчилгээний татварын хөнгөлөлтөд хамруулахыг даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Швед улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль²-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар энэ хуулийн 2, 3 дугаар зүйлд заасан тохиолдлоос бусад бүх үйлчилгээнд 25 хувийн татвар ногдуулдаг.³ Зорчигч тээврийн үйлчилгээнд татварын хөнгөлөлт үзүүлэх тухай заалт нь Нэмэгдсэн өртгийн албан татварын удирдамж (2006/112/ЕС)-ийн 98 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон III хавсралтын 5

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.domstol.se/globalassets/filer/domstol/hogstaforvaltningsdomstolen/2020/engelska-oversattningar/case-no.-54-20.pdf>, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² Mervärdesskattelag (1994:200), https://www.riksdagen.se/sv/dokument-och-lagar/dokument/svensk-forfattningssamling/mervardesskattelag-1994200_sfs-1994-200/, (Сүүлд үзсэн: 2025.02.05)

³ Швед улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд зааснаар нэмэгдсэн өртгийн албан татвар 25 хувь байдаг. Харин ном, сонин зорчигч тээврийн үйлчилгээ гэх зэрэг үйлчилгээнд 19 хувийн татвар ногдуулдаг бол ресторан катерингийн үйлчилгээ болон үсчин зэрэг бусад үйлчилгээнд 13 хувийн татвар ногдуулдаг. <https://marosavat.com/manual/vat/sweden/>



дахь заалтад үндэслэсэн. Тус заалтад зорчигч болон тээш тээвэрлэх үйлчилгээнд татварын хөнгөлөлт үзүүлж болно гэж заасан байдаг.

VOI Technology AB-ийн үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй тайлбараас үзэхэд компани нь зөвхөн үйлчлүүлэгч өөрөө ашиглах зориулалттай тээврийн хэрэгслээр хангадаг нь тодорхой байна. Тиймээс энэ үйлчилгээ нь зорчигч тээврийн бус, харин тээврийн хэрэгсэл түрээслэх үйлчилгээ гэж Швед улсын Захиргааны хэргийн шүүх үзжээ. Иймд шүүхээс нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, Татварын агентлагийн гаргасан шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

---o0o---